ОРХОН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ДЭРГЭДЭХ
СТАТИСТИКИЙН ХЭЛТЭС

Аж үйлдвэр, барилга, үйлчилгээний салбарын танилцуулга

Орхон аймаг
2019 он

АГУУЛГА

1. Судалгааны зорилго

2. Аж үйлдвэр, барилга, үйлчилгээний салбаырн үүсэл хөгжил

3. Аймгийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулах бизнесийн орчин

4. Аймгийн аж үйлдвэр, барилга, үйлчилгээний салбарын өнөөгийн байдал

- Аж үйлдвэрийн салбарын нийт үйлдвэрлэлт
- Аж үйлдвэрийн салбарын ажиллагчдын тоо, аймгийн нийт ажиллагчдад эзлэх хувь
- Аж үйлдвэрийн гол нэрийн бүтээгдэхүүн үйлдвэрлэл
- Барилгын салбарын нийт үйлдвэрлэлт, аймгийн ДНБ-д нэмэгдэл өртгийн эзлэх хувь
- Барилга угсралт, их засварын ажлын гүйцэтгэл
- Худалдааны салбарын нийт борлуулалт, нэмэгдэл өртгийн хэмжээ, аймгийн ДНБ-нд нэмэгдэл өртгийн эзлэх хувь
- Худалдааны салбарын ажиллагчдын тоо, аймгийн нийт ажиллагчдад эзлэх хувь, дэд салбараар
- Нийтийн хоолны салбарын нийт бараа гүйлгээ
- Тээврийн салбарын үзүүлэлтүүд
- Холбооны салбарын үзүүлэлтүүд

5. Дүгнэлт, санал

1.СУДАЛГААНЫ ЗОРИЛГО

Аймгийн эдийн засаг, дэд бүтцийн үндсэн үзүүлэлтээр нэгдсэн танилцуулга бэлтгэн, эдгээр үзүүлэлтүүдэд гарсан өөрчлөлт, цаашдын чиг хандлагыг тодорхойлон, орон нутгийн удирдлага, бодлого хариуцсан ажилтнуудыг мэдээллээр хангахад чиглэнэ.

2. АЖ ҮЙЛДВЭР, БАРИЛГА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ САЛБАРЫН ҮЙЛ ХӨГЖИЛ

Аж үйлдвэр

Аймгийн аж үйлдвэрийн салбар нь анх 1976 онд уул уурхайн олборлолт, мод боловсруулах чиглэлээр үүсчээ. 1980 оноос ноос, ноосон нэхмэл, оёдол, хэвлэл, хүнсний бүтээгдэхүүн үйлдвэрлэл, цахилгаан дулаан эрчим хүч үйлдвэрлэл, төмөрлөгийн үйлдвэр, барилгын материал үйлдвэрлэл, нефть боловсруулах үйлдвэрлэл, шахмал түлш, цаас, эмийн ургамал, гоо сайхны бүтээгдэхүүн боловсруулах, шингэн шил химийн бүтээгдэхүүн үйлдвэрлэл, цахилгаан утас, ацетелин вакум буюу хуванцар бүтээгдэхүүн үйлдвэрлэл, арьс, арьсан бүтээгдэхүүн үйлдвэрлэл, хоёрдогч түүхий эд боловсруулах, түлш, хөөсөнцөр хавтан үйлдвэрлэл, шилэн хийц, цахилгаан гэрэл чийдэн, түүхий резин, баяжмалын даавуун шүүлтүүр, плитаны цавуу, хар замаск, бэлтгэлийн хувцас үйлдвэрлэл гэх мэт жил бүр хөгжсөөр 2018 оноос тамга, кардонон хайрцаг, цаасан тор, ногоон тэжээл, кимчи, савласан тактуритан, гагнуурын электрод үйлдвэрлэл бий болж өргөжсөөр байна.

Барилгын салбар

Орхон аймгийн барилгын байгууллагуудын үүсэл хөгжил нь зэс-молибдений уул уурхайн баяжуулах “Эрдэнэт” үйлдвэр, Эрдэнэт хотыг барьж байгуулсантай холбоотой.

Уул уурхайн баяжуулах “Эрдэнэт” комбинат, Эрдэнэт хотын барилга байгууламжийг барих ажлын ерөнхий гүйцэтгэлээр ЗСБНХУ-ын хүнд үйлдвэрийн барилгын яам өөрийн яамны харъяа “Главзарубежстрой” байгууллагад “Мед молибденстрой” барилгын удирдах газрыг 1974 онд байгуулан Эрдэнэтэд төлөврүүлжээ. Ерөнхий гүйцэтгэч “Медмолибденстрой” удирдах газрын харъяанд гурван удирдах газар болон бусад туслан гүйцэтгэгч байгууллагууд байгуулагдан барилга байгууламжийг барьж хөгжлийг эхэлжээ.

Худалдааны салбар

Эрдэнэт хотын хөгжлийн эхэн үед 11 дэлгүүр, 3 зоогийн газар, нийт 14 худалдааны цэг ажиллаж байсан бол худалдаа үйлчилгээний хөгжил, зах зээлийн хүрээ өдрөөс өдөрт нэмэгдэн тэлсээр эдүгээ 742 худалдааны нэгж, салбар, 232 ахуйн үйлчилгээний цэг үйл ажиллагаа явуулж байна.

Тээвэр, холбооны салбар

Өргөн уудам нутагтай, хүн ам харьцангуй сийрэг суурьшдаг манай орны хувьд тээвэр нь эдийн засгийн амьдралд чухал ач холбогдолтой салбарын нэг билээ. Аймгийн тээврийн салбар 1974 онд газ-53, 2-автобус, 2-автомашинтай нийт 5 ажилчинтай авто баазын сууриар үүсчээ. Зах зээлийн харилцааны дагуу тэлж хөгжсөөр эдүгээ хотын дотор 12 маршрутад 65 автобус, 10 микро автобус, 28 таксийн зогсоолын чиглэлээр 468 суудлын автомашинаар иргэдэд нийтийн тээврийн үйлчилгээ үзүүлж байна.

Орхон аймгийн холбооны салбар нь 1970 оноос Эрдэнэтийн овооны зэс молибденыг олборлох үйлдвэрийг барьж ажил эхэлсэнээр Эрдэнэт хот, түүнийг дагаад холбоо харилцаа үүсч хөгжсөн байна. Геологийн тосгоны 7-р байранд 30-аад ажилтантай, хот хоорондын холбоо, хотын холбоо, шуудан тасагтайгаар зохион байгуулагдаж, найрамдлын шинэ залуу хотын олон мянган бүтээн байгуулагчдад үйлчилж эхэлсэн байна. Энэ үед АТС 50/200 маркын автомат телефон станц, УБ-Дархан хоттой харилцах ПВ-12-2, СВК-4, Булган аймагтай харилцах В-3-3 олон сувгийн агаарын шугамын нягтруулгын төхөөрөмжийг тус тус суурилуулан, ТУ-100 өсгөгчөөр радио өргөн нэвтрүүлгийн программыг дамжуулж байжээ.

Аймагт мэдээлэл харилцаа холбооны үйлчилгээг үүрэн телефоны үйлчилгээ эрхлэгч операторууд, интернет үйлчилгээ эрхэлж буй цэг нэгж, хэвлэл мэдээлэл гээд төрийн болон бизнесийн 50 гаруй аж ахуйн нэгж үйл ажиллагаа явуулж байна.

3. АЙМГИЙН НУТАГ ДЭВСГЭРТ ҮЙЛ АЖИЛЛАГАА ЯВУУЛАХ БИЗНЕСИЙН ОРЧИН

Орхон аймаг нь Монгол улсын төв хэсэгт оршдог. Улаанбаатар хотоос 371 км-ын зайд байрладаг бөгөөд Булган, Сэлэнгэ аймагтай хиллэдэг. Далайн түвшнээс 1200 метрт өргөгдсөн, 84.4 мян.га газар нутагтай. Эрс тэс уур амьсгалтай. Өвөлдөө -20С хүртэл хүйтэрч, зундаа +30С хүртэл халдаг. Хур тунадас их унадаг.

Аймгийн хэмжээнд 2018 оны жилийн эцсийн байдлаар 103217 хүн ам, 28959 өрх бүртгэгдсэн. Аймгийн төвд нийт өрх хүн амын 95.2 хувь нь оршин суудаг. Хангайн бүсийн хөгжлийн тулгуур төв болсон Эрдэнэт хот дэд бүтэц харьцангуй хөгжсөн нийслэл Улаанбаатар хот, Дархан-Уул аймаг, Сэлэнгэ аймагтай засмал зам болон төмөр замаар холбогдсон, Эрдэнэт-Булган-Хөвсгөлийн чиглэлд засмал замтай болсон нь зах зээл өргөжин хөгжих нөхцөл болж байна.

Гадаад харилцааны хувьд 6 улсын 11 хоттой “Найрамдал харилцаа” –тай бөгөөд 1999 оноос гадаад харилцаагаа өргөжүүлсэн юм. БНХАУ-ын Бугат, Ордос, Манжуур хот, Эрээн хот, ОХУ-ын Улан-Үдэ, Усолье Сибирск, Булгар улсын Бургас, БНТУ-ын Эдремит

хот, Кувейт улсын Эль-Фарваниях, ХБНГУ-ын Миттавайда хот, Швед улсын Сигтуна, АНУ-ын Аляск мужийн Файрбанкс хот, Чек улсын Плзен, БНУУ-ын Сэкэшфэхервар хот, БНСУ-ын Шихэн хотуудтай найрамдал хамтын ажиллагаатай ажилладаг, монголын арилжааны бүх банкны салбартай, шатахуун нийлүүлэлтийн 6 компаний 23 түгээх станц, авто машины газ борлуулалтын 5 түгээх цэг үйл ажиллагаа эрхэлдэг.

Харилцаа холбооны хувьд автомат станц, шилэн кабель, Мобиком, Скайтел, Юнител, G мобайлын үүрэн телефон холбоотой, насанд хүрсэн хүн бүр үүрэн телефон хэрэглэгч байна.

Эрчим хүчний өндөр хүчдэлийн цахилгаанаар хангагдсан ба Эрдэнэт Булганы ЦТС нь Булган аймагт цахилгаан түгээн борлуулдаг.

Гадаад худалдааны хувьд төмөр замаар урд болон хойд хөрштэй шууд харилцдаг.

Орхон аймгийн эдийн засгийн голлох салбар нь уул, уурхайн олборлох үйлдвэр бөгөөд Ази тивд тэргүүлэх 10 уурхайн тоонд багтдаг “Эрдэнэт үйлдвэр” ТӨААТҮГ жилд 27.0 сая тонн хүдэр боловсруулж, 4.5 мянган тонн молибдений баяжмал үйлдвэрлэдэг.

4. АЙМГИЙН АЖ ҮЙЛДВЭР, БАРИЛГА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ САЛБАРЫН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ

Аж үйлдвэр

- *Аж үйлдвэрийн салбарын нийт үйлдвэрлэлт*

Манай аймагт аж үйлдвэрийн 3 салбарын 20 дэд салбарын нийт 166 цэг нэгж үйлдвэрлэл эрхлэн зах зээлд нийлүүлж байгаагаас уул уурхайн олборлох аж үйлдвэрийн салбарт 2, боловсруулах салбарт 162, цахилгаан дулааны эрчим хүчний салбарт 2 нэгж үйлдвэрлэл эрхлэн 170-аад нэрийн бүтээгдэхүүн үйлдвэрлэж байна.

2018 онд 2.3 их наяд төгрөгийн бүтээгдэхүүн үйлдвэрлэн, 2.4 их наяд төгрөгийн бүтээгдэхүүн борлуулсан нь өмнөх оноос үйлдвэрлэлт 12.1 хувиар, борлуулалт 10.2 хувиар өссөн байна.

Нийт бүтээгдэхүүний 88.6 хувь уул уурхайн олборлох салбарт, 9.8 хувь боловсруулах салбарт, 1.5 хувь цахилгаан эрчим хүч, дулаан үйлдвэрлэлийн салбарт бий болжээ.

Зураг 1. Бүтээгдэхүүн үйлдвэрлэлтийн салбарын бүтэц, 2018 он

Зураг 2. Нийт бүтээгдэхүүний үйлдвэрлэлт, тэрбум төгрөгөөр



Хүснэгт 1.Бүтээгдэхүүн үйлдвэрлэлт, борлуулалт, салбараар /сая.төг/

Салбарын ангилал	Нийт бүтээгдэхүүн, оны үнээр		Аж үйлдвэрийн борлуулалт		2018/2017=%	
	2017	2018	2017	2018	Нийт бүтээгдэхүүн, оны үнээр	Борлуулалт
БҮГД	**2082914.2**	**2302079.9**	**2232407.4**	**2448431.3**	**110.5**	**109.7**
УУЛ УУРХАЙ, ОЛБОРЛОХ АЖ ҮЙЛДВЭР	**1927012.2**	**2039986.6**	**1891375.1**	**2024806.1**	**105.9**	**107.1**
Металлын хүдэр олборлолт	1926895.6	2039874.5	1891239.4	2024694.0	105.9	107.1
Бусад ашигт малтмал олборлолт	116.5	112.1	135.7	112.1	96.2	82.6
БОЛОВСРУУЛАХ АЖ ҮЙЛДВЭР	**121260.1**	**226467.5**	**306639.7**	**387982.6**	**186.8**	**126.5**
Хүнсний бүтээгдэхүүн үйлдвэрлэл	14439.1	28307.6	17263.0	31274.9	196.0	181.2
- Мах махан бүтээгдэхүүн үйлдвэрлэл	*2862.0*	*21510.6*	*3289.1*	*22243.4*	7.5[2]	6.8[2]
-Сүү, сүүн бүтээгдэхүүн үйлдвэрлэл	*973.8*	*666.2*	*1106.1*	*840.9*	68.4	76.0
-Үр тарианы гурил, малын тэжээл	*7036.4*	*2345.9*	*8902.6*	*3920.9*	33.3	44.0
-Хүнсний бусад бүтээгдэхүүн үйлдвэрлэл	*3414.6*	*3354.3*	*3742.5*	*3748.3*	98.2	100.2
-Архи, дарс, ундаа үйлдвэрлэл	*152.2*	*430.6*	*222.8*	*521.4*	2.9[2]	2.3[2]
Ноосон нэхмэлийн үйлдвэрлэл	34830.6	35198.0	37605.7	38060.0	101.1	101.2
Оёдлын үйлдвэрлэл	5472.4	6713.5	5418.5	6885.5	122.7	127.1
Арьс шир боловсруулах, ширэн эдлэл, гутал үйлдвэрлэл	30.4	23.7	20.4	9.7	78.0	47.6
Мод модон эдлэл үйлдвэрлэл	11.7	23.4	59.1	38.0	199.7	64.3
Тавилга үйлдвэрлэл	81.9	48.1	161.2	128.4	58.7	79.7
Хэвлэх үйлдвэрлэл	668.8	837.3	770.8	1072.1	125.2	139.1
Химийн бүтээгдэхүүн үйлдвэрлэл	72.6	73.0	84.1	88.4	100.6	105.2
Түлш үйлдвэрлэл	-	78975.0	-	81000.0		
Хуванцар бүтээгдэхүүн үйлдвэрлэл	1090.1	1579.9	1496.0	2095.8	144.9	140.1
Төмөрлөг бус эрдэс бодисоор хийсэн эдлэл үйлдвэрлэл	4303.0	5097.5	3156.5	4830.8	118.5	153.0
Төмрийн үйлдвэрлэл	58146.4	64775.2	237263.2	217716.7	111.4	91.8
Машин тоног төхөөрөмжөөс бусад төмөр эдлэл үйлдвэрлэл	1559.8	3562.0	2709.9	3228.5	2.3[2]	119.1
Цахилгаан машин, хэрэгсэл үйлдвэрлэл	422.4	1008.1	438.3	1287.5	2.4[2]	2.9[2]
Цаас, цаасан бүтээгдэхүүн үйлдвэрлэл	14.0	12.6	8.3	11.1	89.7	134.5
Хоёрдогч түүхий эд бэлтгэл	116.7	232.6	184.8	255.2	199.3	138.1
ЦАХИЛГААН, ХИЙ, ДУЛААН ҮЙЛДВЭРЛЭЛ	**34642.0**	**35625.8**	**34392.6**	**35642.6**	**102.8**	**103.6**

- *Аж үйлдвэрийн салбарын ажиллагсдын тоо, аймгийн нийт ажиллагсдад эзлэх хувь*:

1976 онд 135 ажиллагсад ажиллаж байсан бол жилд дунджаар 2.5 хувиар нэмэгдсээр 2018 онд 8852 болж аймгийн нийт ажиллагсдын 35.9 хувийг эзэлж байна.

Хүснэгт 2. Аймгийн аж үйлдвэрийн үндсэн үзүүлэлтүүд, *сая.төгрөг*

Он	Үйлдвэрлэлт, оны үнээр	Борлуулалт	Ажиллагсдын тоо	Хөдөлмөрийн бүтээмж	Нэг өдрийн үйлдвэрлэлт	Нэг хүнд ногдох аж үйлдвэрийн бүтээгдэхүүн
2012	1296781.6	1288387.0	8986	144.3	3602.2	14.3
2013	1271736.3	1268782.9	9254	137.4	3532.6	13.9
2014	1389976.1	1444643.1	9118	152.4	3861.0	14.9
2015	1243437.1	1303592.0	9004	138.1	3454.0	12.6
2016	1386964.6	1499028.9	8579	161.7	3852.7	13.6
2017	2082914.2	2232416.0	8634	241.2	5785.9	20.1
2018	2302079.9	2448431.3	8852	246.9	6289.8	22.3

2018 оны байдлаар нэг ажиллагч 246.9 сая төгрөгийн, нэг өдөрт 6289.8 сая төгрөгийн бүтээгдэхүүн бий болгож байна.

Нэг хүнд ногдох аж үйлдвэрийн бүтээгдэхүүний хэмжээ 2018 онд 22.3 сая төгрөг болж өмнөх оноос 10.9 хувиар өссөн байна.

- *Аж үйлдвэрийн гол нэр төрлийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлт:*

Аж үйлдвэрийн бүтээгдэхүүний нэр төрөл жил бүр нэмэгдсээр өнөөгийн байдлаар 170- аад нэр төрлийн бүтээгдэхүүн гаргаж байна.

Зэс, молибдений баяжмалаас гадна катодын зэс, хивс, эсгий, эсгий шаахай, оёмол хөнжил, нэхмэл хөнжил, ноос ноолууран нөмрөг, ороолт, шаль, сүлжмэл бүтээгдэхүүн, малын мах, хөх тарианы гурил зэрэг бүтээгдэхүүнийг экспортод гаргаж бусад бүтээгдэхүүнийг өөрийн аймагт болон бусад орон нутгийн зах зээлд нийлүүлж байна.

Хүснэгт 3. Гол нэр төрлийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлт, биет хэмжээ

□	M□□ □□□ □□□□□□□□ □□□□□□□□□□□	H□□□□□ □□□□	2017	2018	2018 / 2017 %
1	□□□□□□ □□□□□□ □□□□□□	□□□ □□	595.1	586.0	98.5
2	н □□□□□□□□□ □□□□□□	□□	5759.3	5485.8	95.3
3	ж□□□□□□ □□□, 99%	□□	14644.0	14173.5	96.8
4	□□□□□□□□□ □□□□ □□□	□□□□□□□ □□□	130.7	402.1	3.1 [2]
5	□□□□□□□ □□□□ □□□	□□□ M□□□	916.2	962.4	105.0
6	с□□□□	□□□ □	281.2	309.6	110.1
7	□□□□□□□	□□□ үү	829.9	514.9	62.0
8	M□□□□ I □□□□□	□□	6192.1	2224.3	35.9
9	M□□□□ II □□□□□	□□	632.1	175.3	27.7
10	H□□□□	□□	2448.8	825.9	33.7
11	к □□□□□ □□□□	□□	798.1	802.8	100.6
12	с□□□	□□	265.8	305.9	115.1
13	M□□□□	□□	16.6	43.3	2.6 [2]
14	H□□□	□□□ □2	443.5	466.6	105.2
15	□□□□	□□□ □	45.6	42.2	92.5
16	е□□□□□ □□□□□□, □□□□	□2	10718.7	11249.7	105.0
17	□ □□□□□□□□□□ □□□□□□□	□3	220.4	305.1	138.4
18	н □□□□□ □□□□□□	□□	205.2	478.9	2.3 [2]
19	M□□ □□□□□ □□□□/□□□□□□□□□□□/	□□	2433.5	3824.5	157.2

Зураг 3. Аж үйлдвэрийн гол нэр төрлийн бүтээгдэхүүний хөгжлийн түүх



Их барилга

- *Барилгын салбарын нийт үйлдвэрлэлт, нэмэгдэл өртгийн хэмжээ, аймгийн ДНБ-д нэмэгдэл өртгийн эзлэх хувь*

Хүснэгт 4 . Нэмэгдэл өртөг, сая.төг

Үзүүлэлт	Дүн (сая төгрөг)		Аймгийн НБ-нд эзлэх хувь	
	2017	2018	2017	2018
Нэмэгдэл өртөг	68213.4	72658.6	3.9	5.6

Өмнөх онтой харьцуулахад барилгын салбарын нэмэгдэл өртөг 6.5 хувиар их байна.

Эдүгээ 100 гаруй барилгын байгууллага жилд дунджаар 80.0 орчим тэрбум төгрөгийн барилга угсралт, их засварын ажлыг хийж гүйцэтгэж байна.

Хүснэгт 5. Их барилгын салбарын зарим үзүүлэлтүүд

		Барилгын байгууллагын тоо	Ажиллагсадын тоо	Гүйцэтгэсэн БУА,их засвар, сая.төг	Орон нутгийн төсвийн хөрөнгөөр, сая.төг	Барилгын нэг ажилтны бүтээмж, мян.төг
2018		123	1540	58117.6	23648.1	37.7
2019		144	3011	84828.8	18683.3	28.2
Өсөлт, бууралт	тоо	21	1471	26711.2	-4964.8	-9.5
	хувь	117.1	195.5	146.0	79.0	74.8

2018 онд 84.8 тэрбум төгрөгийн барилга угсралт, их засварын ажил гүйцэтгэсний 22.0 хувь нь буюу 18.7 тэрбум төгрөгийн ажлыг орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хийж гүйцэтгэжээ.

Зураг 4. Гүйцэтгэсэн барилга угсралт, их засварын ажил, *сая төгрөг*



Нэг ажилтны бүтээмж 28.2 мянган төгрөг болсон нь өмнөх оноос 25.2 хувиар буурчээ.

Хүснэгт 6. Барилга угсралт, их засварын ажлын хэмжээ, сая төгрөг

	2017	2018	2018/2017	
			хувь	тоо
Барилга угсралт их засварын ажлын дүн	**58 117.6**	**84 828.8**	**146.0**	**26 711.2**
Их засварын ажил	21 916.6	24 752.5	112.9	2 835.9
Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн БУА, их засвар	23 648.1	18 683.3	79.0	-4 964.8
Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн БУА, их засвар	3 975.9	5 642.3	141.9	1 666.4

Гүйцэтгэсэн ажлын 29.2 хувь буюу 24.8 тэрбум төгрөг нь их засварын ажил байна. Өмнөх оноос гүйцэтгэсэн нийт ажлын хэмжээ 46.0 хувиар, их засварын ажил 12.9 хувиар өсчээ. Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 18.7 тэрбум төгрөгийн, улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 5.6 тэрбум төгрөгийн барилга угсралт, их засварын ажил хийж гүйцэтгэсэн нь өмнөх оноос улсын төсвийн хөрөнгөөр хийгдсэн ажил 41.9 хувиар өсч, орон нутгийн төсвийн хөрөнгөөр хийгдсэн ажил 21.0 хувиар буурчээ.

Худалдааны салбар

- *Худалдааны салбарын нийт борлуулалт, нэмэгдэл өртгийн хэмжээ, аймгийн ДНБ-нд нэмэгдэл өртгийн эзлэх хувь*

Аймгийн худалдаа нийтийн хоолны 733 цэг салбар 142.2 тэрбум төгрөгийн бараа гүйлгээ хийж, бараа гүйлгээний нийт хэмжээ өмнөх оноос 24.6 хувиар өссөн байна.

Өмнөх оноос барааны дэлгүүр, шатахуун борлуулалт, хүнсний дэлгүүр, зоогийн газрын бараа гүйлгээ, барилгын материалын дэлгүүр, эм борлуулалт, контейнерын орлого 1.4-87.5 хувиар өсч, ТҮЦ-ний орлого 84.2 хувиар, авто сэлбэгийн дэлгүүрийн орлого 16.5 хувиар, авто засварын газрын орлого 2.8 хувиар буурчээ. Нийт бараа гүйлгээний 98.1 хувь нь Баян-Өндөр суманд хийгджээ.

Хүснэгт 7. Худалдаа, нийтийн хоолны бараа гүйлгээ

ХУДАЛДАА, НИЙТИЙН ХООЛНЫ БАРАА ГҮЙЛГЭЭ, сая төгрөг

Үзүүлэлт	2017		2018		2018 / 2017 %
	цэгийн тоо	бараа гүйлгээ	цэгийн тоо	бараа гүйлгээ	
БҮГД	**742**	**114128.3**	**733**	**142234.9**	**124.6**
Барааны дэлгүүр	75	9576.8	73	9708.7	101.4
Хүнсний дэлгүүр	385	41821.9	378	54717.4	130.8
Согтууруулах ундааны гүйлгээ	296	12829.9	295	19411.2	151.3
Авто сэлбэгийн дэлгүүр	18	1316.8	21	1100.1	83.5
Барилгын материалын дэлгүүр	19	2187.3	21	2986.9	136.6
Зоогийн газар	139	19541.9	141	23633.3	120.9
Ресторан бар	86	7169.3	86	9092.2	126.8
ТҮЦ	6	17.1	2	2.7	15.8
Контейнер	6	303.3	6	568.7	187.5
Авто засварын газар	29	307.9	26	299.4	97.2
Шатахууны борлуулалт	12	33764.2	10	39747.6	117.7
Газын борлуулалт	5	4595.8	4	4731.5	103.0
Эм борлуулалт	53	5291.1	55	9470.1	179.0
1000 хүнд ногдох бараа гүйлгээ, сая.төг	**1122.7**		**1378.0**		
Худалдааны нэг цэгт ногдох хүн	**137**		**141**		

Нийт бараа гүйлгээний 38.5 хувийг хүнсний дэлгүүр, 27.9 хувийг шатахуун борлуулалт, 16.6 хувийг зоогийн газар, 6.8 хувийг барааны дэлгүүр, 6.7 хувийг эм борлуулалт, 2.1 хувийг барилгын материалын дэлгүүр, 0.8 хувийг авто сэлбэгийн дэлгүүрийн орлого, 0.4 хувийг контейнер, 0.2 хувийг авто засварын газрын орлого эзэлж байна.

Зураг 5. Бараа гүйлгээ, бүтцээр



- *Худалдааны салбарын ажиллагчдын тоо, аймгийн нийт ажиллагчдад эзлэх хувь, дэд салбараар*

2018 оны байдлаар 1000 хүнд 1378.0 сая төгрөгийн бараа гүйлгээ ногдож, өмнөх оноос 255.3 сая төгрөгөөр өссөн байна.

Аймгийн нэмэгдэл өртгийн 4.9 хувь нь худалдааны салбарт бий болж, энэ нь өмнөх оноос 0.3 пунктээр өссөн байна.

Хүснэгт 8. Худалдааны салбарын нэмэгдэл өртөг

Үзүүлэлт	Дүн (сая төгрөг)		Аймгийн НБ-нд эзлэх хувь	
	2017	2018	2017	2018
Нэмэгдэл өртөг	62395.8	8995.8	4.6	4.9

Хүснэгт 9. Худалдааны салбарын ажиллагсадын тоо

Үзүүлэлт	Тоо		Аймгийн нийт ажиллагсдад эзлэх хувь	
	2017	2018	2017	2018
Худалдааны салбарт ажиллагсад	5788	6692	18.0	19.2

Худалдааны салбарт ажиллагсадын тоо өмнөх оноос 904 буюу 15.6 хувиар өсч, аймгийн нийт ажиллагсдад эзлэх хувийн жин 1.2 пунктээр нэмэгджээ.

Худалдааны салбарын хөдөлмөрийн бүтээмж, *сая төг*

Салбарын нэг ажилтны бүтээмж 2010-2013 онд жилд дундажаар 42.4 хувиар өсч байсан бол 2014-2015 онд буурч, 2018 онд 21.2 сая төгрөг болж өмнөх оноос 7.6 хувиар өссөн байна.

Зураг 6. Худалдааны салбарын бүтээмж



➢ *Нийтийн хоолны салбарын бараа гүйлгээ*

Нийтийн хоолны 141 цэг салбар үйл ажиллагаа явуулж байна. 2018 онд нийт 23.6 тэрбум төгрөгийн гүйлгээний орлоготой ажилласан нь өмнөх оноос 20.9 хувиар өссөний дотор ресторан баарны орлого 26.8 хувиар, цайны газрын орлого 17.4 хувиар өсчээ.

Зураг 7. Нийтийн хоолны салбарын бараа гүйлгээ, *мянган төгрөг*

Нийтийн хоолны бараа гүйлгээний 38.5 хувийг ресторан баарны орлого, 61.5 хувийг цайны газрын орлого эзэлж байна. Нийтийн хоолны салбарын 1000 хүнд ноогдох бараа гүйлгээ 230.3 сая төгрөгт хүрч өмнөх оноос 38.1 сая төгрөгөөр нэмэгдсэн байна.

Тээвэр, харилцаа холбоо

➢ *Тээврийн салбарын үзүүлэлт*

Зураг 8. Тээврийн салбарын үзүүлэлт

2018 онд тээврийн салбарт 18.5 тэрбум төгрөгийн, холбооны салбарт 7.1 тэрбум төгрөгийн нэмэгдэл өртөг бий болсон нь 2017 оноос 10.5-25.1 хувиар өссөн байна.

Тээвэр, холбооны салбарын дотоодын нийт бүтээгдэхүүн аймгийн нийт нэмэгдэл өртгийн 1.0 хувь, хангайн бүсийн 0.5 хувийг бүрдүүлж байна.

Хүснэгт 10. Тээврийн салбарын эргэлт

	Хэмжих нэгж	2016	2017	2018	2018/2017 %
Тээсэн ачаа	мян.тн	168.9	153.7	192.3	125.1
Ачаа эргэлт	м/т/км	50 419.9	51 154.1	68 112.9	133.2
Тээсэн зорчигч	мян/хүн	5 287. 0	4 908. 0	6 267.5	127.7
Зорчигч эргэлт	м/хүн/км	101 568.5	101 242.1	165 521.9	163.5
Тээврийн орлого	сая.төг	22 705.3	17 881.8	18 513.5	103.5
Тээврийн үйлчилгээнд гарсан:					
Автобус	тоо	56	70	65	92.9
Микро автобус	тоо	34	27	10	37.0
Такси	тоо	535	503	468	93.0
Тээврийн үйлчилгээ эрхэлж буй:					
ААН	тоо	10	10	12	120.0
Ажиллаж буй хүн	тоо	838	878	796	90.7

2018 онд аймгийн дүнгээр 12 аж ахуйн нэгжийн 796 ажиллагсад 65 автобус, 10 микроавтобус, 468 такси тээврийн үйлчилгээ явуулж 192.3 мян.тн ачаа тээвэрлэн, 68.1 сая.тн/км-ийн ачаа эргэлт, 6.2 сая зорчигч тээвэрлэн, 165.5 сая.хүн/км–ийн зорчигч эргэлт гүйцэтгэж 18.5 тэрбум төгрөгийн орлоготой ажиллажээ. Өмнөх оноос тээврийн орлого 3.5 хувь, зорчигч эргэлт 63.5 хувь, ачаа эргэлт 33.2 хувиар тус тус өсчээ.

- *Холбооны салбарын үзүүлэлт*

Холбооны орлого 2017 онд 6.4 тэрбум төгрөг байсан бол 2018 онд 7.2 тэрбум төгрөгт хүрч, 2017 оноос 11.5 хувиар буюу 741.0 сая төгрөгөөр өсчээ. Телевизорын тоо өмнөх оноос 3.5 хувиар буюу 585 цэгээр өсч, Кабелийн телевизийн цэгийн тоо 39.3 хувиар буурч, радио цэгийн тоо өмнөх оны түвшинд байна.

Хүснэгт 11. Холбооны салбарын үзүүлэлт

	2016	2017	2018	2018/2017 %
Нийт орлого, сая төгрөг	7 678.9	6 425.2	7 166.2	111.5
Хүн амын орлого, сая.төг	7 017.3	5 890.3	6 653.4	113.0
Нийт орлогоос: Интернэт	51.2	23.3	19.1	82.0
КАТВ, TV	1 590.6	1 625.5	1 786.3	109.9
Үүрэн телефон	4 980.6	3 896.1	4 657.5	119.5
Монголын цахилгаан холбоо	1 062.5	441	279	63.3
Төмөр замын холбоо	7.2	14.3	13.5	94.4
Мэдээлэл холбооны сүлжээ	399.2	425.0	410.8	96.7
Суурин телефон цэг, тоо	4 532	4 074	3 706	91.0
Айл өрх	1 224	879	950	108.1
Радио цэг, тоо	3 298	3 298	3 237	98.2
Телевизор, тоо	16 396	16 680	17 265	103.5
Үүрэн телефон хэрэглэгчид, тоо	215 479	240 694	285 670	118.7
карт эзэмшигчид, тоо	204 375	225 452	264 986	117.5
Кабелийн телевизийн цэг,тоо	15 388	14 223	8 628	60.7
Таксафон, тоо	1	1	1	100.0
Интернэт: Цэгийн тоо	9	9	3	33.3
Үйлчлүүлэгчдийн тоо	38 282	26 647	12 161	45.6
Байнгын хэрэглэгч	6 455	6 624	8 396	126.8

Аймгийн хэмжээнд үүрэн телефон хэрэглэгчийн тоо 285.7 мянга болж өмнөх оноос 18.7 хувиар буюу 45.0 мянган хэрэглэгчээр нэмэгдэж, 6-аас дээш насны нэг хүнд 3 орчим үүрэн телефоны дугаар оногдож байна. Холбооны салбарын нийт орлогын 92.7 хувийг хүн амаас орсон орлого эзэлж буй бөгөөд бүх орлогын 65.8 хувь нь үүрэн телефоны орлого байна. 2018 онд интернет цэгүүд 12.2 мянган хүнд үйлчилж 19.1 сая төгрөгийн орлого олсон нь өмнөх оноос 18.0 хувиар буурсан байна. Интернэт хэрэглэгчдээс байнгын 8.4 мянган хэрэглэгч байгаа нь өмнөх оноос 26.8 хувиар их байна.

5. ДҮГНЭЛТ, САНАЛ

Манай аймагт аж үйлдвэрийн 20 дэд салбарын 166 аж ахуйн нэгж, иргэд үйлдвэрлэл эрхлэн 170- аад нэр төрлийн бүтээгдэхүүнийг үйлдвэрлэн гаргаж байна.

2018 онд аймгийн аж үйлдвэрийн салбарт үйлдвэрлэгдсэн бүтээгдэхүүн улсын хэмжээний аж үйлдвэрийн нийт бүтээгдэхүүний 12.6 хувь, бүсийн нийт бүтээгдэхүүний 96.0 хувийг бүрдүүлж байна.

Бүсийн аймгуудтай харьцуулахад харьцангуй өндөр байгаа нь аж үйлдвэржсэн хот болохыг илтгэж байна.

Аймгийн хувьд голлох салбар уул уурхай, олборлох аж үйлдвэрийн салбар хэдий ч энэ салбар нэг нэгжээс шууд хамааралтай. Харин боловсруулах салбар нийт үйлдвэрлэлтийн 9.8 хувийг эзэлж, үйлдвэрлэлтийн хэмжээ сүүлийн жилүүдэд жилд дунджаар 30.2 тэрбум төгрөгөөр өсч нэр төрөл нэмэгдэж байгаа нь цаашид хөгжүүлэх боломжтой салбар зайлшгүй мөн гэдэг нь харагдаж байна. 2018 онд боловсруулах салбарын нийт үйлдвэрлэлтийн 34.9 хувийг түлш үйлдвэрлэл, 28.6 хувийг төмрийн үйлдвэрлэл, 15.5 хувийг ноосон нэхмэлийн үйлдвэрлэл, 12.5 хувийг хүнсний бүтээгдэхүүн, 3.0 хувийг оёдол, 2.3 хувийг төмөрлөг бус эрдэс бодисоор хийсэн эдлэл, 1.6 хувийг машин тоног төхөөрөмжөөс бусад төмөр эдлэл үйлдвэрлэл, 0.7 хувийг резинэн болон хуванцар бүтээгдэхүүн үйлдвэрлэл, үлдсэн 0.9 хувийг цахилгаан хэрэгсэл үйлдвэрлэл, хэвлэх үйлдвэрлэл, тавилга үйлдвэрлэл, хоёрдогч түүхий эд бэлтгэл, химийн бүтээгдэхүүн үйлдвэрлэл, мод, модон эдлэл үйлдвэрлэл, ширэн эдлэл, гутлын үйлдвэрлэл, цаас, цаасан бүтээгдэхүүн үйлдвэрлэл эзэлж байна. Боловсруулах аж үйлдвэрийн салбар дотроо “Эрдэнэт үйлдвэр” ТӨААТГ-ыг дагаад төмөрлөгийн үйлдвэр ихээхэн хувийг эзэлсээр ирсэн. Мөн сүүлийн жилүүдэд оёдол, хүнсний бүтээгдэхүүний үйлдвэрлэлт нэмэгдсээр байна.

Сүүлийн жилүүдэд барилга угсралтын ажил нилээд явагдаж томоохон орон сууцнууд баригдаж байсан боловч 2018 оны хувьд барилга угсралтын ажил их, их засварын ажил буурсан байна. Улсын дүнд 1.8 хувь, бүсийн дүнд 30.0 орчим хувийг эзэлж улсад эхний 5-т жагсаж байна.

Төсвөө өөрөө бүрдүүлж, өөрийгөө санхүүжүүлдэг аймгийн хувьд нийт гүйцэтгэсэн барилгын ажлын 30.0 орчим хувийг орон нутгийн төсвийн хөрөнгөөр хийдэг байна.

Дэлхий нийтийн хөгжил, хүн амын хэрэглээний чиг хандлагын өөрчлөлттэй уялдан манай аймагт сүүлийн жилүүдэд олон улсын стандартад нийцсэн худалдаа, үйлчилгээ, нийтийн хоолны газрууд олноор бий болж байна. Эдгээрээс худалдааны салбар нь аймгийн дотоодын нийт бүтээгдэхүүний 4.9 хувь, үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн

нэгжүүдийн 35.4 хувийг бүрдүүлж манай аймгийн эдийн засагт томоохон байр суурь эзэлдэг салбарын нэг юм.

Түүнчлэн, худалдааны салбар нь хөдөлмөрийн зах зээлд онцгой үүрэг гүйцэтгэдэг салбаруудын нэг бөгөөд 2018 оны байдлаар тус салбарт 6.7 мянган хүн ажиллаж байна.

Өмнөх онтой харьцуулахад бараа гүйлгээний 24.6 хувийн өсөлтөнд барааны дэлгүүр болон хүнсний дэлгүүр, шатахуун борлуулалт, барилгын материалын дэлгүүрийн орлого, зоогийн газрын орлого ихээхэн хувь эзэлж байна.

Өмнөх онтой харьцуулахад 1000 хүнд ногдох бараа гүйлгээ 255.3 сая.төгрөгөөр өссөн нь худалдааны салбарын өсөлтийг харуулж байна.

Бараа гүйлгээний хэмжээ өссөн нь ажиллагсдын тоо өссөн ч хөдөлмөрийн бүтээмжийн өсөлтөд бараа гүйлгээний өсөлт шууд нөлөөлж байна.

Худалдааны нэг цэгт ногдох хүний тоо 2018 оны жилийн эцэст 141 болж, өмнөх оноос 2.9 хувиар нэмэгджээ.

Өнөөгийн монголын цахилгаан холбоо компани нь одоогийн мэдээлэл харилцаа холбооны хөгжлийн суурь болсон байна. Өнөөдөр мэдээлэл харилцаа холбооны салбар хэвийн тогтвортой, технологийн тасралтгүй үйл ажиллагааг хангаж, эдийн засгийн үр өгөөж, техник технологийн оновчтой шийдлийн үндсэн дээр хэрэглэгчээ чанартай үйлчилгээгээр хангаж ажиллаж байна.

Мэдээлэл харилцааны хөгжлийн дүнд үүрэн телефон хэрэглэгчдийн хэрэглээ нэмэгдэж, үүнтэй холбогдон телефон цэгийн тоо 9.0 хувиар буурсан байна. 6-аас дээш насны хүн ойролцоогоор 3 орчим үүрэн телефоны дугаартай байна.

Тээвэр, холбооны салбарын дотоодын нийт бүтээгдэхүүн аймгийн нийт нэмэгдэл өртгийн 1.0 хувь, хангайн бүсийн 0.5 хувийг бүрдүүлж байгаа нь тус аймгийн эдийн засгийн дэд бүтцийн эдгээр салбар бусад орон нутгаас харьцангуй сайн хөгжснийг харуулна.

2018 онд авто тээврээр 192.3 мянган тонн ачаа тээвэрлэж, ачаа эргэлт 68122.9 мянган тонн километрт хүрсэн нь 1990 оноос хойш хамгийн өндөр үзүүлэлт болж байна.

Хамруулсан хугацаа

Үзүүлэлтүүдийг ихэвчлэн 2017-2018 оноор зарим шаардлагатай график дүрслэлийг 2010-2018 оны байдлаар авч, өөрчлөлтийг өмнөх онтой харьцуулан тодорхойлов.

Мэдээллийн эх үүсвэр

- Аймгийн Статистикийн эмхэтгэл, 2018 он
- Статистикийн мэдээллийн нэгдсэн сан – 1212.mn сайт
- Монгол улсын статистикийн эмхэтгэл, 2018 он /урьдчилсан гүйцэтгэл/